

“ХҮҮХДИЙН УРАН ЗОХИОЛЫН НЭГЭН ТУЛГАМДСАН АСУУДЛЫН ТУХАЙ”

Д.Оюунбадрах, доктор (Sc.D), МУБИС

Аннотация: В литературоведении принято считать, что детская литература в Монголии начала развиваться с 50-ых годов XX века. Это связано с тем, что именно с того времени у нас впервые появились такие жанры детской литературы, как литературная сказка, детский рассказ, повести и пьесы для детей и т.д. И в настоящее время монгольская детская литература имеет много своих талантливых представителей, которые славятся немалыми интересными произведениями. Однако в настоящее время перед нашей детской литературой выдвигаются новые, продиктованные веянием времени, задачи, которые заключаются в том, чтобы творить произведения, отвечающие современным требованиям и психологическим особенностям детей XXI века с умелым применением новых и эффективных приёмов художественного изображения.

Түлхүүр үг: сэдэв өргөжих, дүр дүрслэл, ур чадвар, төрөл зүйл, хүүхдийн зохиолч, адал явдал, хөгжөөнт аяс

“Тавь жараад оны манай хүүхдийн утга зохиол нийт утга зохиолын ерөнхий бүрэлдэхүүнээс бие даан хөгжих чиглэлд оржээ.” Энэ нь Монголын орчин цагийн хүүхдийн зохиол өөрийн гэсэн дүр төрхөө олсон тухайд хэлсэн үг. Үүнийг батлах хэд хэдэн зүйл бий. Хамгийн чухал нь тавиад оны сүүл үеэс эхлэн хүүхдийн зохиолыг дагнан бичдэг зохиолчид буй болсон явдал юм. Энэ зохиолчдын эгнээ жараад оны үеэс өргөжин С.Надмид, Ж.Дашдондог, Д.Давааням, Д.Гармаа, Ч.Арьяасүрэн, Т.Жамьянсүрэн, Ч.Лувсандэндэв, Сэгсмээ, Г.Жанчив, Л.Соронзонболд нарын шинэ авьяастнууд гарч ирсэн байна.

Эдгээр зохиолчдын бас нэг онцлог нь тус бүрдээ хүүхдийн зохиолын аль нэг төрлийг голлон барьж авсан нь хүүхдийн уран зохиолын төрөл зүйлийг олшруулахад нөлөөлж, эдүгээ хүүхдийн зохиолд байвал зохих төрөл зүйл бүрээр ямар нэгэн хэмжээгээр зохиол бүтээлээ туурвисаар байна. Үүнийг дагалдаад сэдвийн хүрээ өргөжиж, бичих, дүрслэх ур чадвар жилээс жилд харьцангуй ахиж байна. Монголын зохиолчдын гуравдугаар их хурлын тайлан илтгэлд “Монголын уран зохиол хөөрөх жигүүртэй боллоо. Энэ жигүүрийн гуурс нь шинэ

үеийн романууд юм” хэмээн тэмдэглэжээ. Энэ бол улс орны уран зохиолын хөгжилтийг хэмжих нэг үзүүлэлт мөн. Бид ч урьд өмнө энэхүү зарчмыг баримтлан хүүхдийн уран зохиолд роман тууж, найраглал мэтийн томоохон хэлбэрийн зохиолууд буй болсноор шинэ шатанд гарсан гэж үзэж байна. Үнэхээр жараад оноос хойш Б.Ренчиний “Заан залуудай” I, II эр /1964, 1966/, Ө.Баасанжавын “Алтан хараацай” /1971/, З.Сандаагийн “Шальдар булдар нас” /1982/, М.Чимидийн “Сэтгэлийн нууц” /1982/, Ш.Шажинбатын “Товийн зүүд” /1983/ зэрэг роман Л.Түдэв, С.Надмид, Д.Гармаа, Ч.Арьяасүрэн, Г.Жанчив нарын тууж, Д.Даржаа, Д.Содномдорж нарын туульсын болон баатарлаг явдлын найраглал зэрэг томоохон хэлбэрийн зохиолууд гарсан нь хүүхдийн уран зохиолын хөгжлийн шинэ шатны нэг үзүүлэлт мөн болно. Энэ үүднээс авч үзвэл жижиг ёгт үлгэрээс эхлээд роман, богино шүлгээс аваад туульсын найраглал, шог үзэгдлээс бүрэн хэмжээний жүжиг гээд манай хүүхдийн зохиолд ер дутуу юм үгүй болсон шиг харагдана.

Гэвч ерөөс хүүхдийн зохиол гэгч ямар онцлогтой ямар хэмжүүр шалгууртай болох талаас нь авч үзвэл бас нэг өөр дүгнэлт гарах юм. Хүүхдийн зохиолд байвал зохих бүхий л төрөл зүйл ямар нэг хэмжээгээр буй болсон ч бид жараад оноос хойших бүтээлийг жинхэнэ хүүхдийн зохиолын шаардлага зүйн үүднээс задлан шинжилж, дүгнэн цэгнэж үзвэл үнэн дүр зураг тодроно. Бидний судалгааны гол зорилго ч үүнд оршиж байна. Хүүхдийн зохиолд тавигддаг нэгэн гол зарчим бол адал хөгжөөнт явдал юм. Энэ нь ялангуяа туульсын зохиолын хувьд бүр ч илүү чухал. Хүүхдийн зохиолыг роман гэх үү гэхээсээ адал хөгжөөнт явдал нь аль хэр байгаагаар нь хэмжвэл илүү ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, энэ чанараараа л хүүхдийнх үү, том хүнийх үү гэдэг нь бараг ялгарах учиртай. Тийм ч учраас хэдий хүүхдэд зориулж бичээгүй ч энэ байдал нь давуу зохиолууд хожмоо хүүхдийн уншлагад ордог байна. Аман зохиол, эртний бичгийн зохиолын бүтээлүүдээс хүүхдэд хамааруулахдаа ч бид энэ зарчмыг баримталдаг. Орчин цагийн монголын хүүхдийн уран зохиолын эхний үеийн бүтээлүүдэд энэ чанар ямар нэг хэмжээгээр байгаа тухай бид өмнө бүлэгт авч үзсэн. Тэр чанар нь алдагдахаараа сонирхолгүй, нэг загварын бүтээлүүд гарч ирсэн

тухайд шүүмжлэлтэй хандсан.

1960-аад оноос хойших уран бүтээлүүд харьцангуй энэ чанар нь давуу болсноороо өмнөх үеэс ялгагдах учиртай. Үүнийг үл харгалзан зөвхөн роман, тууж гэсэн ойлголтоор авч үзвэл учир дутагдалтай болно. Дээр өгүүлсэн романууд бол жараад оноос хойш гарсан хүүхдийн гэх бараг бүх роман юм. Харин эндээс жинхэнэ хүүхдийн болж чадсан эсэхийг мөнөөх хэмжүүрээр авч үзэж болно. Жишээ нь: “Алтан хараацай романы хувьд хэлбэр зохиомж нь сонин болсон нь нэг талаас тус тусдаа бие даасан жижиг өгүүлэг мэт байвч эдгээр нь Дүүдээ гэх гол баатрын эргэн дурсагдах бодлоор холбогдон нэг шугамд орж нэг зохиол болж байгаа юм. Ийм ч учраас зохиолч романаа “Хэлхээ найруулал буюу дурсамж роман” гэж нэрлэсэн нь, оновчтой болжээ. [С-139-191] Энэ бол олон салангид үйл явдлыг нэг зохиол болгодог дорно дахины уран зохиолын аргыг шинэ нөхцөлд тохируулан авч ашигласанаараа нийгэм, түүхийн хүрээ цараа ихтэй өргөн үйл явдлыг хүүхдэд дүрслэн үзүүлэх талаасаа зөв шийдэл болсон юм.

Сүүлийн үед М.Чимидийн “Сэтгэлийн нууц”, С.Надмид “Нийслэлийн замд”, Ш.Шажинбат “Говийн зүүд”, З.Дорж “Сүүтэй чулуу” зэрэг орчин үеийн амьдралаас сэдэвлэсэн романууд гарчээ. Эдгээр нь дор бүрийдээ шинийг эрэлхийлсэн хүүхдийн утга зохиолд байгаа онгорхой зайг нөхөх гэсэн эрмэлзэл, хандлага буй нь сайшаалтай. С.Надмид романаа сургуулийн бага насныханд зориулсан байна. Эл зохиолд өвөө, эцэг, хүү гэсэн гурван үеийнхний амьдрал, замналын тухай өгүүлж, өнгөрсөн, одоо үеийн нийгмийн амьдралын хүрээг хамран, энэ хүрээнд багтах үйл явдлыг дурсамж, бодлын хэлбэрээр илэрхийлж, адал явдал, хөгжөөнт аясыг нэлээд хэмжээгээр оруулахыг хичээсэн нь сайшаалтай.

М.Чимидийн “Сэтгэлийн нууц” романд ахлах ангийн хүүхдийн үерхэл, нөхөрлөл, анхны хайр дурлалын тухай өгүүлжээ. Зохиолын гол баатар 10-р ангийн сурагч Агиймаа, Базарсад нар бол хичээл сурлагадаа сайны дээр биеийн тамир, спортод дуртай, хоорондоо дотно үерхдэг хүүхдүүд юм. Энэ үерхлийг ангийн багш Жаргалмаа ч зөв ойлгодог байжээ. Гэтэл Агиймаагийн ээж огт өөрөөр ойлгож элдвээр хардаж, сэрдэхийг урьдал болгож байна. Энэ нь 2 хүүхдийн цаашдын үерхэлд муугаар нөлөөлж байгаа юм. Гэтэл Базарсадыг эмнэлэгт хэвтэх үеэр түүний хажуу тасгийн Гэрэл охин чин сэтгэлээсээ тусалж байсан нь Базарсадад түүн рүү татагдан Агиймаагаасаа хөндийрөх болж байна. Эл явдлыг Агиймаа огт төсөөлөхгүй, Агиймааг Базарсадтай үерхдэгийг Гэрэл бас мэдэхгүй байгаа нь уг зохиолын адалд,

сонин явдлууд үүдэн гарахын шалтгаан болж байна. Гэвч зохиолын уран сайхны боловсруулалт дутагдаж, зөвхөн чулуу хөөлгөсөн үйл явдлаар уншигчдыг төөрөлдүүлсэн нь уг зохиолын гол дутагдал юм. Ганц жишээг хэлэхэд л Гэрэлийг ердөө л Базарсадтай танилцуулахын тулд зохиолч өөрөө аваачаад эмнэлэгт хэвтүүлчхэж байгаа юм. Шүүмжлэгчдийн үзсэнээр сүүлийн үеийн зарим романыг уншсаны дараа сэтгэлд хоногшин үлдэх дүр хомс, туульсийн том хэлбэрийн зохиолд хамарвал зохих хүрээ, далайц бага зохиолын санаа ядмаг байгаа зэрэг нь хүүхдийн гэсэн нэр бүхий романуудад ч ажиглагдаж байна.

Хүүхдийн романгэгч онолын нэлээд маргаантай асуудлын нэгэн бөгөөд заавал романтик болсноор зохиол өндөр шатанд хүрнэ гэж үзвэл эндүүрэл болно. Дээрх зохиолууд хүүхдэд зориулсан туульсийн том хэлбэрийн зохиол байх дүрийн өсөлтийн учир зүйн холбоо, адал хөгжөөнт аяс, үйл явдлын өргөн цар хүрээг илэрхийлж чадахгүй байна.

1960-аад оноос хойш хүүхдэд зориулагдсан бүтээлийг ажиглаж үзэхэд романаасаа илүү тууж бичих талдаа манай зохиолчид илэрхий амжилт олж байна гэж хэлж болохоор ажээ. Дээр өгүүлсэн зохиолыг хүүхдийн болгодог нэг гол үзүүлэлт болох адал явдал /прекключение/ сүүлийн үеийн туужид нэлээд нэвтрэх болов. Эдгээр адал явдлыг манай зохиолчид зүгээр нэг үйл явдлын сонинд дулдуйдан уншигчдыг чулуу хөөлгөх замаар бас баатруудын дэврүүн хүсэл мөрөөдөл /Д.Гармаа/, гэнэн хөөрүү сэтгэлийн илрэл /П.Лувсанцэрэн/, хуучнаа дурсах сэтгэлийн уянга /Л.Түдэв/, орчин тойрны нөлөө /Ш.Гаадамба/, томчуудын сургамжаас үүдсэн бодол эргэцүүлэл /С.Надмид/, түүхэн үйл явдал /П.Хорлоо, М.Чимид/ зэрэг өргөн хүрээнд янз бүрийн аргаар бичиж, туршиж буй нь сайшаалтай. Хэдийгээр өнөөдөр манай уран зохиолд хэдийгээр Марк Твений бүтээлүүд шиг алдартай адал явдлын зохиол гараагүй ч дээрх нөхдийн уран бүтээл орчин цагийн монголын хүүхдийн уран зохиолд тодорхой байр суурь эзлэхүйц хэмжээнд хүрч нэгэнт чаджээ. Д.Гармаагийн “Хөгжөөнтэй туужууд” энэ талаар нэлээд дөмөгт нь тооцогдох ба эл зохиол “Гавьяат үйлсийн мөрөөдөл” [1967], “Нэгэн зуны намтар” [1968], “Ерөөлтийн бага хүү” [1968], “Зугаатай зуслан” [1971], “Жаахан Янгуу түүний найз нар” [1972], “Шувууны зуд” [1972], “3 бөхтэй тэмээ” [1973], “Холын цэнхэр тэнгис” [1973] гэсэн цуврал туужуудаас бүрдэж байгаа юм. Эдгээр туужуудын гол баатрууд болох Цэдэн, Баатар, Банзай, Чойсүрэн, Идэр, Лхагва, Навчаа нар янз бүрийн насны хүүхдэд байж болох элдэв адал,

сонин хэрэг явдалд оролцон их төлөв будилж, хөглөх авч, тэр бүхнээсээ ухаарал сууж амьдралд хөлөө аажим аажмаар олж байна.

Ер нь сүүлийн туужуудад адал сонин явдал нь зөвхөн үйл хөдлөлөөр бус баатруудын дотоод сэтгэл санаагаар дамжин илэрч ажилсаг хөдөлмөрч хүүхдийн төрхөнд бие биеэ хайрлах нандин сайхан чанарыг нээн үзүүлжээ. Ингэснээрээ хөгжөөнт аяс аажмаар уянгалаг аяс руу шилжин хүүхдийн сэтгэлийн дотоод ертөнцийг орчин ахуй, амьд байгаль, хүмүүсийн харилцааны явц, хөгжил хөдөлгөөн дунд нь дүрсэлжээ. Энэ бол тухайн насны хүүхдийн “сэтгэл зүйн онцлогоос урган гарсан өнгө аяс” /Ө-120-4/ болно. Ийм өнгө аясаар бичигдсэн зохиолын нэг бол П.Лувсанцэрэнгийн “Усны эргүүлэг буюу Борзооны хэмээх тууж юм. Туужийн гол баатар Хашбат хүү тухайн цаг үеийн сургууль, намыг эсэргүүцэгч дайсны явуулгыг илчлэх гэсэн дэврүүн хүсэлдээ хөтлөгдөн өмнө сонсож байсан үлгэр шиг яриаг ургуулан “Борзоон” хэмээх айхавтар чөтгөрийн тухай зохион ярьж байгаа нь нэг талаар хүүхдийн авьяас билгийн, нөгөө талаар гэнэн дэврүүн сэтгэлийнх нь илрэл болж байна. Гэтэл Хашбат өөрөө эргээд өнөөх Борзооны хань хамсаатанд сэрдэгдэж буй нь тухайн цаг үеийн байдал, хүмүүсийн ухамсрын хэр хэмжээг илтгэнэ. Хашбат мөн л Идэрийн нэгэн адил үүнд бууж өгөлгүй, тэрхүү сургууль тэнхмийг хорлоод буй этгээдэд Борзоон хэмээх нэр өгч түүнийг илэрхийлэхийн тулд бүлэг байгуулан ажиллаж байгаа нь нэг загварын давталт бус ерөөсөө энэ насныхны хийх ёстой ажил мөн. Харин энд А.Гайдарын “Төмөр ба түүний команд” зэрэг зохиолын нөлөө буйг үгүйсгэх аргагүй. Эл зохиолд гадна байдлын хөгтэй үйл явдлыг голлосон бус тэрхүү үйл явдлаас үүдэн баатрын бодол сэтгэхүйд төрсөн эргэцүүлэл ухаарлыг гаргаж бичсэнээрээ онцлог юм. Үүний зэрэгцээ сургууль, танхимыг хорлож буй бодит дайсанд “Борзоон” гэдэг нэр өгсөн, бас тэр дайсныхаа тухай Хашбатын төсөөлөн бодож байгаа, сургууль танхимынхны дунд “Борзоондох” гэсэн үг хэллэг дэлгэрч буй зэрэг нь ардын үлгэрийн мангасын дүрийн уламжлалыг авч эсрэг хүчний хорт үйл ажиллагааг “Борзоони хэмээх хий төсөөллийн баатарт шингээсэн нь энэ зохиолын бас нэг онцлог болж байна. Энэ нь “Та нар муу л юм болбол “Борзоон” гэж ярих дуртай улс. Жинхэнэ том Борзоон чинь тэр дайн л байгаа юм хэмээн Чойдог багшийн хэлж буй үгнээс бүр тодорхой. Мөн “би” баатар буюу нэгдүгээр биеийн өгүүлэмжээр эл зохиол бичигдсэн нь адал хөгтэй явдлыг уянгалаг зөөлөн аястай холбох боломжийг нээж өгсөн байна.

Энэ мэт адал сонин явдлыг зөвхөн үйлдлээр бус баатрын дотоод сэтгэхүйтэй холбон дүрслэх талаар манай зохиолчид өөр өөрсдийн арга барилаар дор бүрийдээ амжилтад хүрч байв. С.Надмидын “Сүүдэр хүү” /1972/ тууж “бүхэл агуулгаараа хүмүүжлийн асуудлыг дэвшүүлсэн” /Ө-118-34/ бөгөөд тун эгзгийг нь олж, хөгжөөн инээдэм дунд сургамжтайгаар өгүүлснээрээ, зохиолын баатрын үйл хөдлөлөөс илүүгээр бодол, сэтгэхүйг нь барьж бичсэнээрээ онцлог юм. Туужийн гол баатар Ганаа хүү “миний хүүгийн толгойд олиггүй жаал орчхоод байгаа юм” гэсэн өвөөгийнхөө үгийг сониуч зангаараа эсрэгцүүлэн бодсоор эцэст нь өөртөө байгаа дутагдлаа олж зассан төдийгүй нөхөддөө хүртэл нөлөөлж буй тухай эл зохиолд өгүүлжээ. Өвөөгийн хэлсэн “Олиггүй жаал”-ын нууцыг олж мэдэх гэсэн хүүгийн хүсэл зохиолын гол зангилаа, цаашид үүдэн гарах олон адал явдлын шалтаг болж байна. Ганаа мөнөөх олиггүй жаалыг эрсээр хотод байхдаа төдийлөн анзаараагүй байсан урт хар сүүдрээ хөдөө очиж гэнэт харж, түүнийг олиггүй жаал байж магадгүй хэмээн бодсон нь гэнэн атлаа айхтар үндэстэй юм. Юу гэвэл монгол хүн буруу, муу юмыг сүүдэртэй зүйрлэдэг бөгөөд зохиолч ч үүнийг бодолцсоны гэрч нь гол баатрын хажуугаар “Сүүдэр хүү” хэмээх нэг сонин дүр гарч ирж буй нь П.Лувсанцэрэнгийн “Борзоон”-той төстэй бөгөөд муу хүчний үйлдлийг хиймэл баатарт шингээн илэрхийлдэг уламжлалт арга энд ашиглагджээ. Энэ зохиолын хамгийн гол ололт, онцлог нь зохиолч хүүхдийн амьдралыг нарийн гярхай ажиглаж олсон санаагаа баатруудын дотоод сэтгэлтэй зөв холбон дэвшүүлсэн асуудлаа тэдний бодол эргэцүүллээр зөв зүйтэй шийдсэн нэг ёсны уран сайхны ололт болсныг харуулж байна.

Жараад оны үеэс хойш Ч.Арьяасүрэнгийн “Сүүлэн хүү”-гийн цуврал өгүүллэгүүд, Д.Гармаагийн “Аав цэцэрлэгт орсон нь”, “Түн түн пин пан буюу ойн дээрэмчдийн адал явдал”, “Ёндон гуайн адал явдал”, Ш.Цэнд-Аюушийн “Адтай Мятав”, Д.Содномдоржийн “Аймхай борхүү, хашин хар морь”, Д.Даржаагийн “Аливаа хорын үндсийг таслагч, ачит билгүүн баатрын шинэ туульс оршивой”, “Орчлонгийн сайхан Сүндэрьсээ” зэрэг нэлээд зохиол энэ чиглэлээр гарсан байна. Ч.Арьяасүрэнгийн “Сүүлэн хүүгийн цуврал өгүүллэгүүд анх 1965 онд “Боов яаж төрөв” хэмээх үлгэр бүхий номоор эхэлж гарчээ. Энэ зохиолын хамгийн гол амжилт нь дүрээ олсон явдал бөгөөд ардын үлгэрт эмгэн өвгөн хоёрын ямааны сүүлнээс амилдаг. Өвгөн Сүүлэн хүүд санасан газар нь саадгүй хүргэх шидэт таяг бэлэглэснээр баатрынхаа үйл явдлыг их өргөн

хүрээнд үргэлжлүүлэх боломж бүхий зохиомжийг хэрэглэсэн байна. Ийнхүү зохиолч “Сүүлэн хүү” /1965/, “Сүүлэнхүү номын оронд” /1973/, “Сүүлэнхүү малчин болсон тухаа үлгэр” /1978/ гэх зэргээр гол баатрынхаа аяллыг үргэлжлүүлсэн юм. Дүрээ зөв сонгож, зохиомжоо эвтэйхэн гаргаж чадсан нь энэ зохиолын гол амжилт мөн боловч үйл явдлыг тухайн цаг үеийн аяст тааруулах үүднээс хэрэггүй газар хэт сунжруулсан, учир зүйн холбоог зарим газар орхигдуулсан, гаднын зохиолын нөлөөнд автсан зэрэг учир дутагдал бий. Зохиолч энэ бүхнийг ухааран уран сайхны боловсруулалттай улам бүр чамбай сайн болгож чадваас зохиолын үйл явдал хэзээ ч хаана ч өрнөх бүрэн боломжтойг онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

Энэ мэтээр 1960-аад оноос хойш манай хүүхдийн уран зохиолд тууж, роман өргөн хүрээг хамарч зохиолчдын бичиж туурвих ур чадварыг ч дэмжиж байсан нь сайшаалтай.

Харин 1990-ээд оноос хойш эдгээр төрөл зогсолтын байдалд орж энэ чиглэлийн зохиол бараг гарахгүй болсон нь тухайн цаг үе нийгмийн байдалтай холбогдох нь тодорхой. Харин сүүлийн үед Надмидын Мандалын “Болсон явдал” хэмээх адал явдлын тун өвөрмөц дүр, дүрслэл бүхий тууж гарч ирсэн нь уншигчдын сонирхлыг ихэд татаж буй төдийгүй ийм чиглэлийн зохиол бичих хойч үеийнхэн гарч ирэх итгэл найдварыг төрүүлж байна. Эл зохиолын гол ололт нь үлгэрийн дүрслэлийн аргыг ашиглаж орчин үеийн амьдралыг тусган бичсэний дээр аль ч насны уншигчдын сонирхлыг татах өвөрмөц баатруудын дүрийг буй болгосон явдал юм. Манай хүүхдийн уран зохиолд чухам л ийм дүрслэл, ийм баатрууд дутагдаж байсныг залуу зохиолч гярхай ажиглаж мэдэрч бас ч уран сайхны хувьд тун дажгүй боловсруулсанд байгаа юм. Тиймээс ч уг номыг гарсан даруйд “Бандхай” гэдэг нэгэн жижигхэн номыг уншаад сэтгэл сэргэж манай монголчуудын авьяас билэг дундаршгүй уурхай лугаа юмаа гэж юутай их баярласан юм. Надмидын Мандал хэмээх нэгэн шинэ залуу зохиолч хүүхдийн зохиолын дэлхийн дэвжээнд зодоглохоор гарч ирснийг уншигч тантайгаа хуваалцахгүй байж чадсангүй” /Ж.Оюунцэцэг/ “Туужийн гарч байгаа үйл явдал үлгэр домогтой сүлэлдэж байгаа нь манай уран зохиолд төдийлөн байдаггүй шинэлэг зүйл болсныг тэмдэглэх учиртай” /Н.Пүрэвдагва/ гэх зэргээр өгсөн уншигчдын дүгнэлт бас нэгийг өгүүлж байна.

ДҮГНЭЛТ

Эцэст нь тэмдэглэхэд Монголын хүүхдийн уран зохиолд байх зайлшгүй чухал эл төрлийг хөгжүүлэн хүүхэд багачуудад зориулсан шилдэг сайн бүтээл туурвих нь манай зохиолч, уран бүтээлчдийн тулгамдсан чухал асуудлын нэгэн болж байна.